



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захиралтай байгуулсан 2023 оны
Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний
биелэлтийг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.9 дэх заалт, "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.7, 9.3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам"-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу 82.33 хувийн үнэлгээ авсан тул гүйцэтгэх захиралтай 2023 онд байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хавсралт ёсоор "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ

“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЭРДЭНЭБУЛГАНТАЙ БАЙГУУЛСАН ОНЦГОЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ

№	Дүгнэх үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		Харьцуулалт		Авбал зохих оноо	ТУЗ-ийн дүгнэлт
			төлөвлөгөө	гүйцэтгэл	2023 он гүйц-төл	2023 он гүйц/төл		
1	Нийт орлого	мян.төг	22,176,346.8	13,853,729.4	-8,322,617.36	0.62	5	3.00
2	Нийт зардал	мян.төг	22,169,869.9	18,919,534.7	-3,250,335.23	0.85	5	5.00
3	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	5,829.2	-6,758,824.4	-6,764,653.61	(1,159.48)	5	2.83
4	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.000	1.401	0.40	1.40	5	3.00
5	Нийт авлага	мян.төг	84,812,544.0	109,486,625.9	24,674,081.95	1.29	5	2.83
6	Нийт өглөг (Өр төлбөр/Эздийн өмчийн зохистой харьцааг харгалзах. 1-с дээш бол эрсдэлд орж эхэлж байгаа, 2-с дээш бол өндөр эрсдэлтэй, Эздийн өмчийн дүн (-) үзүүлэлттэй бол маш өндөр эрсдэлтэй буюу дампуурахад бэлэн болсон)	мян.төг	223,968,546.1	266,617,173.5	42,648,627.39	1.19	5	3.00
7	Хөрөнгө оруулалт /өөрийн хөрөнгөөр/	мян.төг	166,100.0	24,384.0	-141,715.97	0.15	5	4.17
	Хөрөнгө оруулалт /"Солонго 1.2" төслийн нэгж/	мян.төг	819,000.0	-	-819,000.00	-		
8	Хөрөнгийн өгөөжийг сайжруулсан байдал (Нийт хөрөнгө/Татварын өмнөх ашгийн дүн. Сүүлийн 5 жилийн дундаж өссөн дүнгээр харьцуулж үзэх ба харьцуулалтын дүнг харгалзаж зохих оноог өгнө)	мян.төг	7,173.93	(26.27)	-7,200.20	-	10	7.00
9	Төрийн өмчийн ногдол ашгийн гүйцэтгэл улс, орон нутгийн төсөвт өр төлбөргүй байх /тайлант онд татварын өр төлбөргүй ажилласан/	мян.төг	570,991.99	2,499,058.6	1,928,066.61	4.38	10	9.67
Нэг. Эдийн засгийн үзүүлэлт							55	40.50
2.1	Тухайн жилийн тайлан тэнцлийн аудитын дүгнэлт, сүүлийн 2 жилийн зөвлөмжийн хэрэгжилт	2021 оны аудитын дүгнэлтээр 7 албан шаардлага, 6 зөвлөмж өгч, 1 төлбөрийн акт тогтоогдсоноос нийт 92% биелэлттэй, 2022 оны аудитын дүгнэлтээр 2 зөвлөмж, 6 албан шаардлага, 1 төлбөрийн акт, хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал 2 тус тус өгөгдсөнөөс нийт 84% биелэлттэй ажилласан. Тайлант онд 1 төлбөрийн акт, 4 албан шаардлага, 1 зөвлөмж, 1 хариуцлага тооцох албан шаардлага тавигдсан.					5	4.17
2.2	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийн биелэлт	ТӨБЗГ-аас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу авсан арга хэмжээ, биелэлтийг тухай бүр тогтоосон хугацаанд нь албан бичгээр хариу тайлагнасан.					5	5.00
2.3	Худалдан авах ажиллагааны тухай хууль, Шилэн дансны хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн биелэлт	Нийт 24.3 сая төгрөгийн худалдан авалтыг хуулийн дагуу явуулж үйл ажиллагааны тайланг холбогдох байгууллагад илгээсэн. Тайлант хугацаанд шилэн дансанд орлогын 10,748 гүйлгээ, зарлагын 229 гүйлгээг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан.					4	4.00
2.4	Хэрэглэгчийн санал асуулгын дүн	Санал асуулгад оролцсон нийт 421 иргэний 22.9 хувь нь маш сайн, 42.6 хувь сайн хэмээн үнэлсэн бол 10.3 хувь нь дунд, 6.9 хувь нь муу, 17.3 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн нь өнгөрсөн жилийн судалгааны дүнтэй харьцуулахад үнэлгээ буурсан үзүүлэлттэй байна. Цаашид байгууллагын үйл ажиллагааг илүү ил тод, нээлттэй байлгаж, муу хэмээн үнэлсэн иргэдийн хандлагыг эерэг болгох тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.					3	2.57
2.5	Ажиллагсадын санал асуулгын дүн	Судалгаанд оролцогсдын хариултыг нэгтгэн дүгнэвэл ажилтны нийгмийн баталгааг хангах, хүртээмжтэй цалин хөлс олгох, үл ялгаварлал, тэгш хандлага, удирдлагын дэмжлэг, хамт олны харилцаа эерэг байх нь сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чухал хүчин зүйлс хэмээн үзэж, компанийн удирдлагаас гаргаж байгаа шийдвэр нь нээлттэй байхын зэрэгцээ тогтвортой ажлын байр, тасралтгүй сургалт, хүртээмжтэй цалин хөлс, зөв карьер төлөвлөлт, шагнал урамшуулал, тэгш харилцаа, ялгаварлан гадуурхалтгүй, ажлын байрны дарамтгүй, зөв хандлага, тав тухтай ажлын орчин, техник хэрэгслийн бүрэн хангалт, удирдлагын дэмжлэгийг бодлого шийдвэртээ оруулж, цаашид илүү хүртээмжтэй ажиллах шаардлагатай.					3	3.00
Хоёр. Тайлангийн үр дүн							20	18.73
Гурав. Харьяалах салбарын яам, төрийн захиргааны холбогдох байгууллагын үнэлгээ /шийдвэрийн хэрэгжилт/		БХБЯ-ны 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 8/4897 тоот албан бичгээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 92.4%-тай ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН гэж дүгнэсэн					25	23.10
НИЙТ ОНОО							100	82.33